

**ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ  
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 12 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч газар, түүний доор, дээр, агаарын орон зайд хийгдэх геодези, зураг зүйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бүх салбарт хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажил, үйлчилгээг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагааны төрлөөр нийтийн буюу иргэний, тусгай буюу батлан хамгаалах гэж ангилах, салбарууд тус тусдаа хийгддэг байсан байр зүйн зургийг улсын нэгдсэн санд оруулах, нэг эх үүсвэр ашиглах, геодезийн хэмжил, зураглалын ажил, бүтээгдэхүүнд төрийн болон хөндлөнгийн хяналт тавих, эрсдэл үүсэхээс сэргийлэх, газар зүйн нэрийн зохицуулалт зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан бөгөөд хуулийн төслийг [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат иргэд өвөлжөө хаваржааны газарт олон наст ургамал тарьж болох эсэх, орон нутагт сум, багийн хилийн цэсийг шинэчлэн тогтооход маргаан ихээр гардаг асуудлыг хэрхэн зохицуулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал геодезийн тэмдэгт, түүний хамгаалалтын асуудлаар шинээр тусгаж байгаа зохицуулалт, хилийн цэс баталгаажуулах явцад хөдлөл үүсээд талбайн хэмжээ өөрчлөгддөг зөрүү үүсдэг асуудлын талаар нарийвчилсан зохицуулалт нэмж тусгасан эсэх, газрын сангийн зураглалын талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хилийн цэсийг шинэчлэн тогтооход зарим аймгийн талбайн хэмжээ өөрчлөгдөж байгаа шалтгаан, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин аймаг, сумдын хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх, дахин оновчтой тогтоох боломжтой эсэх, Хот байгуулалтын тухай хуулийн төсөлтэй уялдаж байгаа эсэх, суурин газрын солбицлын бие даасан тогтолцооны талаар, Улсын

Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа Газрын багц хуулийн төслүүдтэй уялдуулсан эсэх, газар зүйн мэдээллийн нэгдсэн портал сайтыг ашиглахад салбар хооронд хүндрэл үүсэх, уг мэдээллийн системийг ашиглахад шаардагдах төсөв, зардлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням тухайн аймаг, сум, баг, хорооны хилийн цэсийг шинэчлэн тогтоохдоо түүхэн цаг хугацаанд гарсан тухайн үеийн шийдвэрээр тогтоосон хэмжээг өөрчлөхгүй байх зарчмыг баримтлах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Ардын Их Хурал, Улсын Их Хурлын шийдвэрээр тогтоосон хэмжээг орчин үеийн техник, технологи ашиглан цахим системд бүртгэхдээ өөрчлөлт оруулж, маргаан үүсгэхгүй байхад анхаарах, газар зүйн нэрийн зураглалд байгаа нэрийг өөрчлөхгүй байх, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг уг хуулийн төслийг газрын багц хуулийн төслүүдтэй нийцүүлэх, ажлын хэсгийн түвшинд сайтар нягталж ажиллах шаардлагатай талаар санал хэлсэн болно.


Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Геодези, зураг зүйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.САРАНЧИМЭГ**